



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 68

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5.2.2, 5.2.4, 5.8.в дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дундговь-Ус ОНӨҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 20-61 ДУА улсын дугаартай 2,572,820.00 /Хоёр сая таван зуун далан хоёр мянга найман зуун хорин төгрөг/-ний анхны өртөгтэй, 343,042.64 /Гурван зуун дөчин гурван мянга дөчин хоёр төгрөг жаран дөрвөн мөнгө/-ний хуримтлагдсан элэгдэл бүхий ЗИЛ 555 маркын автосамосваль, 38-90 ДУА улсын дугаартай 25,088,094.78 /Хорин таван сая наян найман мянга ерэн дөрвөн төгрөг далан найман мөнгө/-ний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ГАЗ 3309 маркын автомашин, 38-91 ДУА улсын дугаартай 25,088,094.78 /Хорин таван сая наян найман мянга ерэн дөрвөн төгрөг далан найман мөнгө/-ний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ГАЗ 3309 маркын автомашин, 33-28 улсын дугаартай 139,465,756.1 /Нэг зуун гучин есөн сая дөрвөн зуун жаран таван мянга долоон зуун тавин зургаан төгрөг арван мөнгө/-ний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ТУ-220 маркын бульдозер тус бүрийг сэлбэгийн зориулалтаар актлахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл, Орон нутгийн өмчийн газрын хяналтан дор зохион байгуулж, актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг “Дундговь-Ус” ОНӨҮГазар /Д.Ганбаатар/-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА  С.СУХБААТАР

